



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 4/16

Даланзадгад

Ажлын байрны дагалдан сургалтад хамруулах
тухай

Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/216 дугаар тушаал, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2016 оны 53 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эх, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээг чанаржуулахад эх баригчийн ажлын байранд заагдсан ажил үйлчилгээг бүрэн эзэмшүүлж, мэргэжил ур чадварыг бэхжүүлэх үүднээс сум дундын эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвийн эх баригч нарыг жил бүр ажлын байрны дагалдан сургалтад хамруулсугай.

2. Сургалтад хамрагдах эх баригч эмчийн нэрс, сургалтад хамрагдах хугацааг 1 дүгээр хавсралтаар сургалтын удирдамж чиглэлийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3. Эх баригчийг ажлын байрны дагалдан сургалтад заасан хугацаанд суралцуулах нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг сум дундын эмнэлгийн эрхлэгч, сумын эрүүл мэндийн төвийн дарга нарт даалгасугай.

4. Ажлын байрны дагалдан сургалтыг удирдан явуулах эх барих эмэгтэйчүүдийн эмчийг томилон, дагалдан сургалтаар заавал эзэмших ур чадварыг бүрэн эзэмшүүлж, сургалтын дараах үр дүнг үнэлэн, тайлагнаж ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга /Д.Түвшинзул/-д үүрэг болгосугай

5. Сургалтад хяналт тавьж, тайлан мэдээг нэгтгэн, үр дүнг тооцож ажиллахыг Эрүүл мэндийн газрын хүний нөөцийн мэргэжилтэн /Ц.Мандах/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ӨНӨРЖАРГАЛ

Эрүүл мэндийн газрын даргын
2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн
А/16 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



АЖЛЫН БАЙРНЫ ДАГАЛДАН СУРГАЛТАД ХАМРАГДАХ НЭР,
ХАМРАГДАХ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Сургалтад хамрагдах хугацаа	
			Сургалт эхлэх	Сургалт дуусах
1	Д.Оюунмаам	Ханхонгор сумын ЭМТ	2018-04-23	2018-05-03
2	А.Мэндбаяр	Хүрмэн сумын ЭМТ	2018-04-23	2018-05-03
3	Б.Учрал	Баяндалай сумын ЭМТ	2018-05-04	2018-05-13
4	Д.Өлзийсайхан	Баян-овоо сумын ЭМТ	2018-05-04	2018-05-13
5	Э.Бямбадэлгэр	Булган сумын ЭМТ	2018-05-14	2018-05-23
6	Д.Цогзолмаа	Сэврэй сумын ЭМТ	2018-05-14	2018-05-23
7	Б.Насанжаргал	Гурвантэс сумын ЭМТ	2018-05-24	2018-06-02
8	Б.Жавзан	Ноён сумын СДЭ	2018-05-24	2018-06-02
9		Мандал-Овоо сумын ЭМТ	2018-06-03	2018-06-12
10	Д.Саруулжаргал	Номгон сумын ЭМТ	2018-06-03	2018-06-12
11	Т.Бурмаа	Манлай сумын ЭМТ	2018-06-13	2018-06-22
12	О.Ундармаа	Ханбогд сумын СДЭ	2018-06-13	2018-06-22
13		Цогт-Овоо СЭМТ	2018-06-23	2018-07-03
14	Ю.Орхонтуул	Цогтцэций СДЭ	2018-06-23	2018-07-03

Эрүүл мэндийн газрын даргын
2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн
А/16 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



АЖЛЫН БАЙРНЫ ДАГАЛДАН СУРГАЛТЫН УДИРДАМЖ

Нэг: Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

- 1.1 Жирэмслэлтээс сэргийлэх эм хэрэгслийг сонголт хийлгэх, хэрэглүүлэх талаар мэдээлэл зөвлөгөө өгөхөд суралцах
- 1.2 Үр хөндөлтийн өмнө үйлчлүүлэгчид зөв шийдвэр гаргахад туслах арга барилд суралцах
- 1.3 Бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх, оношилгоо, хавьтлын хамт эрүүлжүүлэх ажлын үр дүнг таниулах
- 1.4 Жирэмснээс сэргийлэх аргад суралцаж, ерөндөг суулгац тавих, авах үйлдлийг хийж сурна
- 1.5 Үр хөндөлтийн явцад гарч болох эрсдэлүүд болон дараах өөрчлөлт хүндрэлүүд гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээлэл өгч сурах
- 1.6 Бэлгийн замаар дамжих халдварыг илрүүлэх, түргэвчилсэн сорилт тавих
- 1.7 Өсвөр үеийн зорилтод бүлэг рүү чиглэсэн нөхөн үржихүйн мэдээлэл сургалт сурталчилгаа хийх

Хоёр: Жирэмсэн эхийн хяналт, мэдээлэл сургалт сурталчилгаа

- 2.1. Жирэмсэн үеийн эрсдэлийг эрт илрүүлж шаардлагатай шинжилгээнд оруулах
- 2.2. Хэвийн явцтай жирэмсний хяналтыг батлагдсан журам зааврын дагуу бүрэн хийж карт хөтлөх
- 2.3. Жирэмсэн үеийн дасгал хөдөлгөөн, зөв хооллолтод суралцах
- 2.4. Жирэмсэн үеийн цус алдалтын үед анхны тусламж үзүүлэх гардан тусламжид суралцах /амин үзүүлэлтүүдийг үзэж үнэлэх, шингэн сэлбэх, хүчилтөрөгч өгөх/
- 2.5. Жирэмсэн эмэгтэй, төрсөн эхэд нэн шаардлагатай амин дэм төмрийн бэлдмэл фолийн хүчил болон бусад бичил элемент үтрээний лаа жор бичиж сурах
- 2.6. Эх барихын гадуур үзлэг /умайн базлалт, ургийн байрлал хөдөлгөөнийг бүрэн хянаж сурах/
- 2.7. Ургийн зүрхний цохилт үтрээний үзлэг умайн хүзүүний эсийн шинжилгээг заалтаар авч сурах
- 2.8. Эхчүүдэд сургалт хийхэд дагалдан суралцах, шинэ мэдээ, мэдээлэл олж авах
- 2.9 Үйлчлэх хүрээний хүн амын дунд жирэмсэн эмэгтэйг эрт илрүүлж хяналтад оруулах

2.10 Жирэмсэн үед эх урагт илэрч болох аюултай шинжүүдийн эрт оношлон, эмчид илгээж, зөвлөгөө авч, эмчийн зөвлөгөөний дагуу эмэгтэйд эрүүл мэндийн тусламж үзүүлэх



Гурав:Төрөх болон төрсний дараах үеийн тусламж

3.1 Хэвийн төрөлтийг эмчийн хяналтад удирдан төрөлтийн түүхэнд партограмм тэмдэглэл бүрэн хөтөлж сурах

3.2 Эмгэг төрөлтийн үед эмчийн удирдлагад хамтран багаар ажиллах

3.3 Ургийн байдал, ургийн зүрхний цохилтыг хэмжих

3.4 Төрөлтийн 3 үеийг удирдаж суралцах ихсийг шалгах, төрөх замыг шалгаж суралцах

3.5 Эх барихын яаралтай тусламж шаардсан манас таталт, цус алдалт үжил дайрлага ураг орчмын шингэний бөглөрлийн үед анхны тусламжийг шуурхай үзүүлж суралцах

3.6 Кесар хагалгаанд эхийг бэлтгэж суралцах

3.7 Төрсөн эхийн амин үзүүлэлт умайн агшилт шавхарга биеийн байдлыг хянах

3.8 Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийг бүрэн үзүүлж суралцах

3.9 Нярайн сэхээн амьдруулалт салиа соруулах, хиймэл амьсгал зүрхэнд иллэг хийх

3.10 Хэвийн төрсөн эхэд бүрэн үзлэг хийх

3.11 Төрсний дараа хүүхдийн асаргаа, хөхөөр хооллолт, хүүхдийн биеийн байдлыг үнэлж сурах

3.12 Дутуу төрсөн нярайд имж-эх асаргааг үзүүлнэ